

# МОНГОЛ ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН УЛС ТӨР, ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

## ЭГЭРЭЛТ-ОД

УЛС ТӨР СУДЛААЧ, ДОКТОР  
МУВИС-ИЙН НХУС-ИЙН НИЙГМИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН БАГШ

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ  
2021 ОН

© Энэхүү бүтээлийг америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд бүтээв.

Бүтээлд илэрхийлэгдсэн үзэл санаанууд нь уг бүтээлийн зохиогчдын үзэл санаа бөгөөд АНУ-ын Засгийн газар, эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.



*Хураангуй: Монгол Улс 1993 оноос эхлэн Ерөнхийлөгчийг дөрвөн жил тутам, нийт долоон удаа бүх нийтээрээ сонгожээ. Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д суудалтай намууд өрсөлддөг. Сонгуулийн үеэр улс төрийн намууд Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хэрэгжүүлэхийг эрмэлзэхдээ нам дотор нэр дэвших болон намууд хооронд хүчтэй өрсөлддөг, үр дүнд нь сонгогчид туйлирах хандлага ажиглагдаж байна. Энэ нь сонгогдсон Ерөнхийлөгчид нэр хүндээ алдах, зарим тохиолдолд нам задрахад нөлөөлсөөр байна. Иймээс энэ өгүүлэл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиуд хэрхэн зохион байгуулагдаж ирсэн, сонгогчид хэрхэн оролцож байсан, улс төрийн намууд яагаад хүчтэй өрсөлддөг болохыг судалж, Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн болон улс төрийн үр дагаврыг шинжилж, цаашид хэрхэн шийдвэрлэх санал, зөвлөмжийг боловсрууллаа.*

**Түлхүүр үг:** Монгол Улс, Ерөнхийлөгч, сонгууль, улс төрийн нам, нэр дэвшигч

## **Оршил.**

Монгол Улс 1924 оноос эхлэн Төрийн тэргүүн гэх албан тушаалыг бий болгож, Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн даргыг нэрлэж эхэлсэн түүхтэй. Хожим УБХ-ыг татан буулгасны дараа Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, дараа нь Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэж байсан. Харин 1990 онд ардчилсан шилжилтийн дараа Ерөнхийлөгч гэх болж, тухайн үеийн нэрээр БНМАУ-ын анхны Ерөнхийлөгчөөр П.Очирбат АИХ-аас сонгогдож байжээ.

1992 онд шинэ Үндсэн хуулийг баталснаар Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгох эрх зүйн шинэ орчин бүрдсэн. Үүний дагуу 1993 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт долоон удаа Ерөнхийлөгчийг бүх ард түмнээсээ сонгожээ. Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь УИХ-д суудалтай намуудын дунд ахисан түвшний өрсөлдөөн болж хувирчээ. Өөрөөр хэлбэл, УИХ-ын сонгуульд сонгогдсон намуудын дараагийн шатны өрсөлдөөн нь Ерөнхийлөгчийн сонгууль болсон байна. Тиймээс өнгөрсөн хугацаанд болсон Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн намууд, нэр дэвшигчид, тэдний дэмжлэг нь эрх мэдлийн төлөөх шинэ өрсөлдөөн юм. Иймээс энэхүү өгүүллээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн онцлог, сонгогчдын оролцоо, намуудын өрсөлдөөн, түүний улс төр, эрх зүйн үр дагавруудыг судаллаа.

## **Судалгааны онол, арга зүй**


Улс төрийн шинжлэх ухаанд ерөнхийлөгч (president) нь латин хэлний “praesident” хэмээх үгнээс гаралтай бөгөөд төрийн тэргүүн, удирдагч гэсэн утгатай Бүгд найрамдах улсын хамгийн өндөр албан тушаалыг хэлдэг<sup>1</sup>. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад засаглалын ямар хэлбэртэй байхаас шалтгаалж Ерөнхийлөгчийн эрх мэдлийг ялгаатай тодорхойлж байна. Тухайлбал, АНУ, Африк, Латин Америкийн орнууд Ерөнхийлөгчийн засаглалтай бөгөөд Төрийн тэргүүн нь засгийн газраа тэргүүлдэг.<sup>2</sup> Харин Европын ихэнх орон парламентын засаглалтай бөгөөд Төрийн тэргүүний эрх

<sup>1</sup> President <https://dictionary.cambridge.org/dictionary/english/president>

<sup>2</sup> Government forms <https://www.britannica.com/topic/president-government-official>

мэдэл харьцангуй сул, билэг тэмдгийн шинжтэй ажээ. Европын зарим орон, тухайлбал, Испани, Их Британи, Скандинавын орнууд Үндсэн хуульт хаант засагтай бөгөөд Төрийн тэргүүний үүргийг хаан гүйцэтгэдэг. Харин Австри, Ирланд, Португалид Ерөнхийлөгчийг шууд сонгодог бол Герман, Итали, Израил, Грек Улсад парламентаас томилдог. Товчхондоо бол Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгодог, эсэхээс хамаарч засаглалын хэлбэр тодорхойлогдож байна.

Зураг 1. Ерөнхийлөгчийн, парламентын, хагас Ерөнхийлөгчийн засаглалын ангилал



Ерөнхийлөгчийн болон парламентын засаглалын ялгаа нь парламент Засгийн газрыг хянадаг, эсэх, Ерөнхийлөгчийг **ард түмнээс тодорхой хугацаатай** сонгодог, эсэхээс шалтгаалж байна.

- Бүх ард түмнээс (popular) сонгогдох гэдэг нь сонгогчид нэр дэвшигчийн төлөө шууд санал өгөх, эсвэл сонгогчдын коллежийг сонгох аргаар Төрийн тэргүүнээ сонгохыг хэлнэ.
- Тодорхой хугацаагаар (fixed term) алба хашна гэдэг нь Төрийн тэргүүний алба хуульд заасан хугацаагаар хязгаарлагдахыг хэлнэ.

Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, танхимыг сонгоход оролцох боловч парламент үл итгэл үзүүлэх замаар үүрэгт ажлаас нь чөлөөлж болдог. Мөн Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, эсвэл Засгийн газраа шууд огцруулах эрхгүй байдаг. Ийм улс орнуудад Алжир, Буркин-Фасо, Кабо-Верде, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Зүүн Тимор, Египет, Франц, Гаити, Литва, Мадагаскар, Мали, Монгол, Нигер, Кипр, Польш, Португал, Румын, Шри-Ланка, Тунис, Украйныг<sup>3</sup> нэрлэж болно.

<sup>3</sup> Semi-presidential [https://en.wikipedia.org/wiki/Semi-presidential\\_republic](https://en.wikipedia.org/wiki/Semi-presidential_republic)

Монгол Улс нь парламентын засаглалтай болохыг Үндсэн хуульд тунхагласан. Үүнийг судлаач Г.Чулуунбаатар Үндсэн хуулийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн” гэсэн нь Монгол Улс парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс гэдгийг батална<sup>4</sup> гэж бичиж байжээ. Гэвч хагас Ерөнхийлөгчийн засаглалтай улс болохыг гадаад, дотоодын судлаачид тодорхойлсон байдаг. Шалтгаан нь Ерөнхийлөгчийн сонгууль, түүнд олгогдсон эрх мэдэлтэй холбоотой ажээ.

Монгол Улс 1990 онд хүний эрхийг дээдэлсэн, олон ургалч үзлийг зөвшөөрсөн, олон намын тогтолцоотой ардчилсан улс болоод 31 жил өнгөрчээ. Энэ хугацаанд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх хангагдаж, улс төрийн олон нам байгуулагдсан<sup>5</sup>, чөлөөт, шударга сонгуулиар УИХ-ын болон орон нутгийн сонгуулийг тус бүр найман удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийг долоон удаа зохион байгуулаад байна. Гэвч ардчиллын талаарх олон нийтийн хандлага явцуу, ардчилсан засаглалын хэтийн төлөв найдваргүй<sup>6</sup>, намын дотоод ардчилал сул<sup>7</sup>, УИХ болон Ерөнхийлөгчийн институт хоорондын эрх мэдэл зөрчилтэй<sup>8</sup>, авлига, ядуурал<sup>9</sup> их гэж судалгааны байгууллагууд, судлаачид дүгнэдэг.

Тиймээс Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүй, сонгогчдын оролцоо, намуудын өрсөлдөөн, нам доторх зөрчлийг дэлгэрүүлэн судаллаа.

### **Нэг. Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүй**

Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүй нь 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлсэн 1993, 2012, 2020 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиуд (МУЕСТХ), 2015 оны Сонгуулийн тухай хууль (СТХ), 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (САСТХ)-уудаас бүрддэг. Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль тогтоомж нь ерөнхийдөө ардчилсан сонгууль явуулах хангалттай үндэс суурийг тавьсан.

Үндсэн хуулийн 30 дугаар зүйлд *Ерөнхийлөгч бол Төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно. 31 дүгээр зүйлд Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож,*

<sup>4</sup> Г.Чулуунбаатар. (1999) Монгол улсын төрийн байгууллагын шинэ тогтолцооны төлөвшлийн тулгамдсан зарим асуудал. Шинэ толь №25

<sup>5</sup> Fritz, V. (2002) ‘Mongolia: Dependent Democratization’, *Journal of Communist Studies and Transition Politics*, 18 (4): 75-100.

<sup>6</sup> Dr. Todd Landman Marco Larizza Claire McEvoy (2005) State of Democracy in Mongolia: A Desk Study. International IDEA. [www.idea.int/files/pictures/sodMongolia05](http://www.idea.int/files/files/pictures/sodMongolia05)

<sup>7</sup> Дефакто институт. Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс. 2018, 2019, 2020 он.

<sup>8</sup> Г.Чулуунбаатар. (1999) Монгол улсын төрийн байгууллагын шинэ тогтолцооны төлөвшлийн тулгамдсан зарим асуудал. Шинэ толь №25

<sup>9</sup> Транспаренси Интернейшнл Монгол. 2020 оны 1 сар.

*Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон, нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын олонхын санал аваагүй бол дахин сонгууль явуулна. 32 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө<sup>10</sup> гэсэн заалттай.*

УИХ Үндсэн хуульд хоёр удаа буюу 2000, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. 2000 оны анхны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Ерөнхийлөгчийн эрх мэдэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт орсон. Харин 2019 оны хоёр дахь нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 30.2-т Ерөнхийлөгч **дөчин таван нас хүрсэн байх** гэснийг **тавин нас хүрсэн байх**, Ерөнхийлөгчөөр ажиллах хугацааг **зургаан жил** болгон өөрчилж, 31.7 дахь зөвхөн нэг удаа улируулан сонгож болохыг цуцалсан юм.

МУЕСТХ-ийг 1993, 2012, 2020<sup>11</sup> онд шинэчлэн баталж, 1995, 2001, 2005, 2006, 2021 онд нэмэлт өөрчлөлт оруулж байжээ. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг 2015 оны Сонгуулийн тухай хуулиар зохион байгуулж байсан. Эндээс харахад Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулиуд дараах онцогтой байна. Үүнд:

1. 1993 оны МУЕСТХ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахдаа хуулийн үндэслэл; сонгууль зарлах, зохион байгуулах; сонгууль эрхлэн явуулах байгууллага, түүний бүрэн эрх; сонгогчдын нэрийн жагсаалт; Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх; санал хураах, анхан шатны сонгуулийн дүн гаргах; санал хураалтыг хүчингүй болсонд тооцох, дахин санал хураах; Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон үед сонгууль зарлан явуулах, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх маргааныг шийдвэрлэх гэсэн есөн бүлэг, 44 зүйлтэй хууль байна.
2. 2012 оны МУЕСТХ нь нийтлэг үндэслэл; сонгуулийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт; сонгогчдын нэрийн жагсаалт; сонгогчдын нэрийн жагсаалт; Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх; сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа; сонгуулийн зардал; санал

<sup>10</sup> Монгол Улсын Үндсэн хууль. (шинэчлэгдсэн эх) 1992 он <https://www.legalinfo.mn/law/details/367>

<sup>11</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулиуд. 1993, 2012, 2020 [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)

хураалтыг хүчингүйд тооцох, дахин болон нэмэлт санал хураалт, дахин сонгууль явуулах; Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах; Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох; Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол, маргааныг шийдвэрлэх харьяалал, журам зэрэг 12 бүлэг, 67 зүйлтэй хууль байна. Энэ хуулийн өмнөх МУЕСТХ-аас ялгаатай нь сонгогчдын саналыг тоолох автомат машин хэрэглэх, гадаадад амьдарч байгаа сонгогчдын саналыг авах, “цагаан сонголт”-той холбоотой шинэчлэл багтжээ.

3. 2015 оны СТХ нь сонгуулийн эрх зүйн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой төрийн болон орон нутгийн сонгуулиудын зохион байгуулалтыг нэгтгэх зорилготой бичигдсэн.
4. 2020 оны МУЕСТХ нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоогоор дахин бичигдсэн бөгөөд нийтлэг үндэслэл; сонгуулийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт; сонгуулийн байгууллага, түүний зохион байгуулалт; сонгогчдын нэрийн жагсаалт; Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх; сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа; сонгуулийн зардал; санал авах, сонгуулийн дүн гаргах; дахин санал хураалт, хоёр дахь санал хураалт, ээлжит бус, дахин сонгууль явуулах; хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол маргаан хянан шийдвэрлэх харьяалал, бусад зүйл гэсэн нийт 11 бүлэг 82 зүйлтэй.

Дээрх хуулиуд нь зохицуулалтын хувьд сайжирч байгаа ч олон улсын байгууллага, судлаачдын дүгнэлтээр дараах сул талууд байсаар байна<sup>12</sup>. Үүнд:

1. Ял эдэлж буй хоригдлуудын саналаа өгөх эрхийг хязгаарлахдаа тэдний үйлдсэн гэмт хэргийн ангиллаас хамааруулж өөрчлөх,
2. УИХ-д суудалтай улс төрийн намууд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх давуу байдлыг өөрчилж, ЕАБХАБ-ын үзэл баримтлал, НҮБ-ын ХЭК-ийн ерөнхий тайлбарт нийцүүлэх,
3. Дахин санал хураалт зохион байгуулсан тохиолдолд сурталчилгааг хүлээн зөвшөөрч хуулиар зохицуулж өгөх гэсэн саналууд өгчээ.

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН


---

<sup>12</sup> Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал болон Орон нутгийн сонгуулийн хуулийн төсөлд өгөх АИХЭГ-ын санал. ЕАБХАБ-ын АИХЭГ. Варшав хот, 2019 оны 11 сарын 25.

## Хоёр. Сонгогчдын оролцоо

Монгол Улс Ерөнхийлөгчийн сонгуулийг УИХ-ын сонгуулиас хойш нэг жилийн дараа зохион байгуулдаг байхаар хуульчилсан. Сонгуулийн товыг УИХ зарладаг. 1993 оноос хойш Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эрх бүхий сонгогчдын тоо нэмэгдэж байна.

Зураг 2. Ерөнхийлөгчийн сонгууль



1993-2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн нэг нь анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхын санал авсан. Харин 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч сонгуульд оролцсон сонгогчдын олонхын саналыг аваагүй тул УИХ дахин санал хураалт зохион байгуулахаар шийдэж, 11 хоногийн дараа зохион байгуулсан.

Хүснэгт 1. Сонгогчдын мэдээлэл<sup>13</sup>

Ерөнхийлөгчийн сонгуулийн жил	1993 он	1997 он	2001 он	2005 он	2009 он	2013 он	2017 он	
Хүн амын тоо	2 199 570	2 245 492	2 388 163	2 533 552	2 616 631	2 870 407	3 132 405	
Сонгуулийн насны хүний тоо	1 159 173	1 241 819	1 398 219	1 578 967	1 642 567	1 998 586	2 032 022	
Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	1 106 403	1 155 228	1 205 885	1 241 268	1 493 217	1 864 273	1 988 891	1 990 797
Саналаа өгсөн сонгогчдын тоо	1 025 970	982 640	1 000 125	930 921	1 098 875	1 239 784	1357788	1 207 787


<sup>13</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиуд, 1993-2017 он. СЕХ. УБ., 2018 он.

СЕХ-ны дээрх мэдээлэлд шинжилгээ хийхэд дараах зүйлс ажиглагдаж байна.

Үүнд:

- 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуультай харьцуулахад сонгуулийн насны иргэдийн тоо 75 хувиар өссөн байна.
- Сонгуулийн насны иргэд ба нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тооны зөрүү 1997 онд 4.5 хувь байсан бол 1997 онд 6.9 хувь, 2001 онд 13.8 хувь, 2005 онд 21.4 хувь болж тогтмол өссөн байна. Харин 2009 онд 9 хувь, 2013 онд 6.7 хувь, 2013 онд 2.1 хувь болж буурч байгаа харагдаж байна.
- 1993 оныг 2017 онтой харьцуулахад саналаа өгсөн сонгогчдын тоо дөнгөж 17 хувийн өсөлттэй байна.

Зураг. 3. Сонгогчдын оролцоо<sup>14</sup>



1993 оноос хойш Ерөнхийлөгчийн бүх сонгуулиудад сонгогчдын оролцоо буурсаар иржээ. Ялангуяа 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар анхан шатны санал хураалтад оролцсон сонгогчдын ирц 68.27 хувь байсан бол дахин санал хураалт явуулахад найман хувиар буурсан байдаг.

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас эхлэн гадаадад амьдарч байгаа иргэд саналаа өгөх эрхийг нээсэн. Энэ нь саналыг санал тоолох автомат машиныг хэрэглэж эхэлсэнтэй холбоотой. 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 39 төлөөлөгчийн газарт гадаадад амьдарч буй 6494 иргэн саналаа өгөхөөр бүртгүүлсэн ч 4242 хүн буюу 68.06 хувь нь сонгуульд оролцсон. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 7374 сонгогч бүртгүүлээд 4816 иргэн буюу 66.8 хувь нь сонгуульдаа оролцсон. Гэвч сонгуульд аль нэг нэр дэвшигч олонхын буюу 50 хувиас илүү санал аваагүй тул дахин санал хураалт зохион байгуулсан. Дахин санал хураалтад гадаадад амьдарч байгаа 7209 иргэн бүртгүүлснээс 2676 иргэн буюу 37.1 хувь нь оролцсон юм.

<sup>14</sup> Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн. ҮСХ. [www.1212.mn](http://www.1212.mn)




Хүснэгт 2. Гадаадаас саналаа өгсөн сонгогчдын тоо<sup>15</sup>

Сонгууль	Дипломат төлөөлөгчийн газрын тоо	Саналаа өгөхөөр бүртгүүлсэн сонгогчийн тоо	Саналаа өгсөн сонгогчийн тоо
2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль	39	6494	4242
2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль	45	7209	4767
	45	4816	2676

2012 оны МҮЕСТХ-д орсон нэг заалт нь “цагаан сонголт” юм. “Цагаан сонголт”-ыг хуулийн 55.10-т Сонгогч нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолох ба энэ тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцно<sup>16</sup> гэж заасан. 2015 оны Сонгуулийн хууль, 2020 оны МҮЕСТХ-д мөн энэ заалт орсон. 2013, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчид “цагаан сонголт” хийх нь огцом нэмэгдсэн. Энэ нь нэр дэвшигчид болон улс төрийн намуудын өрсөлдөөн, кампанит ажлын онцлогтой холбоотой байсан.

Зураг 4. 1993-2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хүчингүй санал болон “цагаан сонголт”<sup>17</sup>



1993-2009 оны Ерөнхийлөгчийн сонгуулиудад сонгогч заавал санал дугуйлах ёстой, тэмдэглэгээ хийгээгүй болон сонголтоос өөр тэмдэглэгээ хийсэн саналыг хүчингүйд тооцдог байсан. Харин 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас эхлэн огт тэмдэглэгээ хийгээгүй сонгогчдын саналыг хүчинтэйд тооцдог болсон нь сонгогчдын улс төрийн эрхийг хүндэтгэж байгаа, нөгөө талаас сонгогчид улс төрийн намууд, нэр дэвшигчдэд таалагдахгүй байгаагаа илэрхийлэх боломж олгосон юм.

<sup>15</sup> Сонгуулийн ирц (сонгогчдын бүртгэл)-ийн мэдээллийг ил тод болгох нь судалгаа. (2021) АНУ-ын ОУХА, ОУБНХ, Азийн сан. Лийд төгсөгчдийн холбоо.

[http://www.leadalumni.org/sites/default/files/Report\\_LEADAA.pdf](http://www.leadalumni.org/sites/default/files/Report_LEADAA.pdf)

<sup>16</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. (2012 он) [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)

<sup>17</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүн. СЕХ. Улаанбаатар. 2017 он.

Хүснэгт 3. 2013, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн “цагаан сонголт”<sup>18 19</sup>

Ерөнхийлөгчийн сонгууль	Нийслэлд	Орон нутагт	Гадаадад	Нийт
2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль	4785 (0.85%)	8875 (1.32%)	28 (0.66%)	13688 (1.1%)
2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль	51739 (9.07%)	47606 (7.5%)	149 (5.27%)	99494 (8.24%)

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар нийслэлийн сонгогчдоос орон нутгийн сонгогчид илүү “цагаан сонголт” хийж байсан. Улсын хэмжээнд нийт сонгогчдын 1.1 хувь “цагаан сонголт” хийсэн. Харин 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар нийслэлийн сонгогчид орон нутгийн сонгогчдоос илүү “цагаан сонголт” хийсэн байна. Улсын хэмжээнд нийт сонгогчдын 8.24 хувь нь “цагаан сонголт” хийсэн нь 2013 оныхтой харьцуулахад найм дахин нэмэгджээ.

#### **Гурав. Намуудын өрсөлдөөн**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн онцлог нь УИХ-д суудалтай намуудаас нэр дэвшүүлж, мөрийн хөтөлбөрөөр өрсөлддөг онцлогтой гэж дээр дурдсан. 1993 оноос хойших Ерөнхийлөгчийн сонгуулиудыг харахад МАН, АН-ын хооронд хүчтэй өрсөлдөөн болжээ. Учир нь энэ хоёр нам нь Монголын намын системд тодорхойлохуйц үндэсний дэмжлэг авдаг, өргөн бүтэц, зохион байгуулалттай, улс төрийн туршлагатай юм.



<sup>18</sup> ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль Ажиглах Хорооны Эцсийн тайлан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль (2013 оны 6-р сарын 26 өдөр)

<sup>19</sup> ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгууль. (2017 оны 6-р сарын 26-н болон 7-р сарын 7-ны өдрүүд)

Хүснэгт 4. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн дэмжлэг

Ерөнхийлөгчийн сонгуулийн жил	1993 он	1997 он	2001 он	2005 он	2009 он	2013 он	2017 он	
Нэр дэвшигчдийн тоо	2	3	3	4	2	3	3	2
МАН-ын нэр дэвшигчийн авсан санал	38.7	60.81	58.13	53.44	47.41	42.52	30.32	41.16
АН-ын нэр дэвшигчийн авсан санал	57.78	29.81	36.53	20.05	51.21	50.89	38.11	50.61
Бусад намын нэр дэвшигчдийн авсан санал		6.64	3.54	25.16		5.58	30.19	
Нэр дэвшигчийн төлөө өгсөн санал	96.48	97.26	98.2	98.65	98.62	98.99	98.62	91.77

- 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН (МАХН)-аас Л.Түдэв, АН (МҮАН, МСДН)-аас П.Очирбат хоёр өрсөлдсөн. Ерөнхийлөгч П.Очирбат УИХ дахь сөрөг хүчний намаас нэр дэвшиж, нийт 592 836 сонгогчийн буюу 57.78 хувийн саналаар сонгогдсон. Харин МАН-ын нэр дэвшигч 397 061 санал буюу 38.7 хувийн дэмжлэг авч ялагдсан.
- 1997 оны Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д олонхын суудалтай МҮАН, МСДН-ын “Ардчилсан холбоо” эвслээс Ерөнхийлөгч П.Очирбат дахин нэр дэвшсэн бол МАН (МАХН)-аас Н.Багабанди, МУНН-аас Ж.Гомбожав нарын гурван нэр дэвшигч өрсөлдсөн. Сонгуульд УИХ дахь сөрөг хүчний нам болох МАН (МАХН)-аас нэр дэвшсэн Н.Багабанди 597 573 санал буюу 60.81 хувийн дэмжлэгээр сонгогдсон. Харин эрх баригч “Ардчилсан холбоо” эвслийн нэр дэвшигч П.Очирбат 292 896 сонгогчийн буюу 29.81 хувийн санал авсан бол МУНН-аас нэр дэвшигч Ж.Гомбожав 65 201 сонгогч буюу 6.64 хувийн дэмжлэг авсан.
- 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д олонхын суудалтай МАН (МАХН)-аас Ерөнхийлөгч Н.Багабанди, сөрөг хүчин болох АН-аас Р.Гончигдорж, ИЗН-аас Л.Дашням нарын гурван нэр дэвшигч өрсөлдсөн. Сонгуульд МАН (МАХН)-аас нэр дэвшсэн Ерөнхийлөгч Н.Багабанди 581 381 сонгогч буюу 58.13 хувийн саналаар дахин сонгогдсон байдаг. Харин сөрөг хүчний нам болох АН-аас нэр дэвшигч Р.Гончигдорж 365 383 сонгогчийн буюу 36.53 хувийн санал авсан бол ИЗН-аас нэр дэвшигч Л.Дашням 35 425 сонгогчийн буюу 3.54 хувийн дэмжлэг авсан.

- 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д олонхын суудалтай МАН (МАХН)-аас Н.Энхбаяр, “Эх орон-Ардчилал” эвслээс М.Энхсайхан, Эх орон намаас Б.Эрдэнэбат, БНН-аас Б.Жаргалсайхан нарын дөрвөн нэр дэвшигч өрсөлдсөн. Сонгуулийн үр дүнд УИХ-д олонхын суудалтай МАН-аас нэр дэвшсэн Н.Энхбаяр 497 491 сонгогч буюу 53.44 хувийн саналаар Ерөнхийлөгчөөр сонгогдсон. Харин сөрөг хүчний нам болох “Эх орон-Ардчилал” эвслээс нэр дэвшигч М.Энхсайхан 186 646 сонгогчийн буюу 20.05 хувийн санал авсан бол Эх орон намын нэр дэвшигч Б.Эрдэнэбат 105 497, БНН-ын Б.Жаргалсайхан 128 784 сонгогчийн санал авсан бөгөөд нийтдээ 25.16 хувийн дэмжлэг авсан.
- 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН (МАХН)-аас Ерөнхийлөгч Н.Энхбаяр, АН-аас Ц.Элбэгдорж нар өрсөлдсөн. Ерөнхийлөгч Н.Энхбаяр УИХ дахь олонхын суудалтай намаас нэр дэвшиж, нийт 520 948 сонгогчийн буюу 47.41 хувийн саналаар ялагдсан. Харин АН-ын нэр дэвшигч Ц.Элбэгдорж 562 718 санал буюу 51.21 хувийн дэмжлэг авч Ерөнхийлөгчөөр сонгогдсон.
- 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д олон суудалтай АН-аас Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж дахин нэр дэвшсэн бол МАН-аас Б.Бат-Эрдэнэ, МАХН (шинэ нам)-аас Н.Удвал (эмэгтэй) нарын гурван нэр дэвшигч өрсөлдсөн. Сонгуульд УИХ дахь олон суудалтай нам АН-аас нэр дэвшсэн Ц.Элбэгдорж 622 794 санал буюу 50.89 хувийн дэмжлэгээр дахин сонгогдсон байдаг. Харин МАН-аас нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ 520 380 сонгогчийн буюу 42.52 хувийн санал авсан бол МАХН-аас нэр дэвшигч Н.Удвал 80 563 сонгогч буюу 5.58 хувийн дэмжлэг авсан.
- 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д олонхын суудалтай МАН-аас М.Энхболд, сөрөг хүчний АН-аас Х.Баттулга, МАХН-аас С.Ганбаатар нар гурван нэр дэвшигч өрсөлдсөн. Сонгуулиар нэр дэвшигчдийн хэн нь ч саналаа өгсөн нийт сонгогчийн олонхын саналыг аваагүй. АН-ын нэр дэвшигч 38.11 хувь, МАН-ын нэр дэвшигч 30.32 хувь, МАХН-ын нэр дэвшигч 30.19 хувийн санал тус тус авсан. Ингээд УИХ хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн дунд 2017 оны долдугаар сарын 7-нд дахин санал хураалт зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Дахин санал хураалтаар АН-ын нэр дэвшигч Х.Баттулга 611 226 сонгогчийн буюу 50.61 хувийн саналаар Ерөнхийлөгчөөр сонгогдсон. Харин МАН-ын нэр дэвшигч М.Энхболд 497 067 сонгогчийн буюу 41.16 хувийн дэмжлэг авсан.

1993 оноос хойш долоон удаа зохион байгуулагдсан Ерөнхийлөгчийн сонгуулиудад нийт 20 нэр дэвшигч өрсөлдсөн. Үүнээс хамгийн их нэр дэвшигчтэй сонгууль нь 2005 онд дөрвөн нэр дэвшигчтэйгээр, хамгийн цөөн нэр дэвшигчтэй сонгууль 1993, 2009 онд тус бүр хоёр хоёр нэр дэвшигчтэй байжээ.

Түүхэнд ганцхан эмэгтэй нэр дэвшигч өрсөлдөж байсан нь 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн Н.Удвал юм.

Ерөнхийлөгчийн сонгуульд хамгийн их сонгогчийн санал авсан нэр дэвшигчдийг харахад АН-аас нэр дэвшсэн Ц.Элбэгдорж, (2013 он), Х.Баттулга (2017 он) нар 600

мянгаас дээш сонгогчийн дэмжлэг авсан. Үүний дараа МАН-ын нэр дэвшигч Н.Багабанди (1997 он), АН-аас нэр дэвшигч П.Очирбат (1993 он), МАН-аас нэр дэвшигч Н.Багабанди (2001 он), АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж (2009 он), МАН-аас нэр дэвшигч Н.Энхбаяр (2005 он), Б.Бат-Эрдэнэ (2013 он) нар 500 мянгаас дээш санал авсан байна. Бусад 12 нэр дэвшигч 500 мянгаас бага санал авчээ.

Хүснэгт 5. 1993-2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиудад хамгийн олон санал авсан нэр дэвшигчид<sup>20</sup>

№	Нэр дэвшигчид	Сонгуулийн жил	Авсан саналын тоо
1	Ц.Элбэгдорж / АН	2013 он	622 794
2	Х.Баттулга / АН	2017 он	611 226
3	Н.Багабанди / МАХН	1997 он	597 573
4	П.Очирбат / МҮАН, МСДН	1993 он	592 836
5	Н.Багабанди / МАХН	2001 он	581 381
6	Ц.Элбэгдорж / АН	2009 он	562 718
7	Н.Энхбаяр / МАХН	2009 он	520 948
8	Б.Бат-Эрдэнэ / МАН	2013 он	520 380

Долоон удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг харахад Үндсэн хуулийн 30.7 дахь “Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно” гэсэн заалтын дагуу Ерөнхийлөгчөөр дахин нэр дэвшиж, сонгогдсон нь Ерөнхийлөгч Н.Багабанди, Ц.Элбэгдорж нар байна. Ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхийлөгч Н.Энхбаяр нар дахин нэр дэвшсэн ч сонгуульд ялагдсан. Харин Ерөнхийлөгч Х.Баттулга 2021 онд дахин нэр дэвшихийг хүссэн ч 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Үндсэн хуулийн цэцийн 2021 оны дөрөвдүгээр сарын 16-ны шийдвэрээр дэвших эрх нь хязгаарлагдсан.<sup>21</sup> Мөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн дээрх буюу 30.7 дахь заалтыг хасаж баталсан.

Ерөнхийлөгч нарын сонгогдсон насыг харахад залуу улс төрчид нэр дэвшиж, ялалт байгуулж байна. Нийт таван Ерөнхийлөгчөөс хамгийн өндөр настай сонгогдсон нь Х.Баттулга (2017 он) бөгөөд дөнгөж 54 настайдаа Ерөнхийлөгчөөр сонгогдож байжээ. Хамгийн залуу нь Ц.Элбэгдорж (2009 он) бөгөөд 46 насандаа Ерөнхийлөгчөөр сонгогдож байв. Ерөнхийлөгч нарын дундаж нас 49.4 байна. Эмэгтэй нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдсон түүх байхгүй байна.

<sup>20</sup> Ерөнхийлөгчдийн авсан санал. ҮСХ. [www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>21</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр. 2021 оны 4 сарын 16-ны өдөр.

Хүснэгт 6. Ерөнхийлөгч нарын сонгогдсон нас

№	Монгол Улсын Ерөнхийлөгч нар	Төрсөн он	Сонгогдсон		Хүйс
			он	нас	
1	П.Очирбат	1942	1993	51	Эрэгтэй
2	Н.Багабанди	1950	1997	47	Эрэгтэй
3		1950	2001	51	Эрэгтэй
4	Н.Энхбаяр	1958	2005	47	Эрэгтэй
5	Ц.Элбэгдорж	1963	2009	46	Эрэгтэй
6		1963	2013	50	Эрэгтэй
7	Х.Баттулга	1963	2017	54	Эрэгтэй
Сонгогдсон дундаж нас				49.4	

**Дөрөв. Намуудын өрсөлдөөн**

Ерөнхийлөгчийн сонгууль нь УИХ-д суудалтай намуудын хувьд дараагийн шатны сонгууль бөгөөд намууд ч мөрийн хөтөлбөр дэвшүүлж идэвхтэй оролцдог. Учир нь УИХ дахь сөрөг хүчний хувь Ерөнхийлөгчийн сонгуулийг төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх арга үздэг. Эрх баригч намуудын хувь эрх мэдлээ баталгаажуулах алхам гэж үздэг. Энэ стратегия ч сонгуулийн кампанит ажилдаа ашигладаг. Судлаач Фернандо Касал Бертао, А.Бат-Оргил нар Монголын Ерөнхийлөгчийн сонгууль нь сөрөг сурталчилгаа, популист амлалт, хүчтэй өрсөлдөөнөөр тодорхойлогддог<sup>22</sup> гэсэн.

Өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулиудыг харахад ихэнх тохиолдолд Ерөнхийлөгч нь УИХ дахь сөрөг хүчнээс сонгогдож байна. Энэ нь хагас Ерөнхийлөгчийн засаглалтай улсад эрх мэдлийг улс төрийн намууд хувааж авах сонирхол, түүнд нийцүүлсэн кампанит ажлын технологитой холбоотой байх.

Хүснэгт 7. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд ялсан намууд

№	УИХ-ын сонгуулиуд	УИХ-д олонх болсон эрх баригч нам	Ерөнхийлөгчийн сонгуулиуд	Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан нам
1	1992 он	МАН	1993 он	МҮАН МСДН
2	1996 он	Ардчилсан холбоо эвсэл	1997 он	МАН
3	2000 он	МАН	2001 он	МАН
4	2004 он	МАН	2005 он	МАН
5	2008 он	МАН	2009 он	АН
6	2012 он	АН	2013 он	АН
7	2016 он	МАН	2017 он	АН

<sup>22</sup> Fernando Casel Bertao and Bat-Orgil Altankhuyag. Are Presidential Elections Putting Mongolian Democracy in Peril? <http://thediplomat.com/2021/05/are-presidential-election-putting-mongolian-democracy-in-peril/>

1993, 1997, 2009, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд сөрөг хүчний нэр дэвшигчид ялалт байгуулж байжээ. Харин 2001, 2005 онд эрх баригч МАН-ын нэр дэвшигч, 2013 онд олон суудалтай АН-ын нэр дэвшигч Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж байжээ.

Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН-аас нэр дэвшихийн тулд нэлээд ширүүн өрсөлддөг. Энэ нь зарим тохиолдолд нам задрахад хүртэл нөлөөлж иржээ. Жишээ нь:

- 2010 онд МАХН нэрээ МАН болгож солих үед 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдсан нэр дэвшигч Н.Энхбаяр нам дотроо зөрчилдөж, МАХН-ыг шинээр байгуулсан. Гол шалтгаан нь 2009 онд Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдахад нам нь дэмжлэг үзүүлээгүй гэж үздэг.
- 2017 онд АН-аас нэр дэвшиж Ерөнхийлөгчөөр сонгогдсон Х.Баттулга АН-аас дахин нэр дэвшихийн тулд нам дотроо өөрийн нөлөөллийг тогтоож, зөрчилдөж байна.

УИХ-д суудалтай гуравдагч хүчний намуудын хувьд болон шинээр байгуулагдсан улс төрийн намууд Ерөнхийлөгчөөр нэр дэвшүүлэх хүний нөөцгүй тул гаднаас нэр дэвшигчээ хайсан байдаг. Үүнд: 1993 онд МҮАН, МСДН-ууд 1990 онд МАХН-аас нэр дэвшиж АИХ-аас сонгогдсон Ерөнхийлөгчийг нэр дэвшүүлж ялалт байгуулж байсан. 1997 онд МУНН МАХН-ын гишүүн, УИХ-ын гишүүн Ж.Гомбожавыг намаас нь урвуулан нэр дэвшүүлж байсан. 2001 онд ИЗН академич Л.Дашнямыг нэр дэвшүүлж байсан.

УИХ-д суудалтай гуравдагч хүчний намуудаас 2005 онд Эх орон намын дарга Б.Эрдэнэбат, БНН-ын дарга Б.Жаргалсайхан өөрсдөө нэр дэвшиж байсан. Мөн 2013 онд МАХН-ын дарга Н.Энхбаяр нэр дэвшихийг хүссэн ч МУЕСТХ-ын ялтай байх хязгаарлалтаас болж дэвших эрхгүй болсон тэрбээр намын гишүүн Н.Удвалыг нэр дэвшүүлсэн. Мөн 2017 онд МАХН-ын дарга мөн адил шалтгаанаар нэр дэвших эрхгүй байсан тул намын гишүүн С.Ганбаатарыг нэр дэвшүүлсэн байдаг.

2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг угтаж МАН МАХН-тай нэгдэх гэрээ байгуулж байгаа нь ердөө Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа хуваахгүй байх улс төрийн стратеги болж харагдаж байна. Учир нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-ын нэр дэвшигч М.Энхболд (411 748 санал) МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатараас (409899 санал) 1849-өөр илүү саналаар эхний шатны хураалтад тэнцэж, дахин санал хураалтаар ялагдаж байсан.

## Дүгнэлт

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталснаар Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгох эрх зүйн шинэ орчин бүрдсэн байна. 1993 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт долоон удаа Ерөнхийлөгчийг бүх ард түмнээсээ сонгожээ. Сонгуульд зөвхөн УИХ-д суудалтай нам нэр дэвшүүлэх эрхтэй учир Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь УИХ-д суудалтай намуудын дунд ахисан түвшний өрсөлдөөн болж хувирчээ. Үүний шалтгаан нь Ерөнхийлөгчийн сонгууль, түүнд олгогдсон эрх мэдэлтэй холбоотой ажээ.

1. Монгол Улс Үндсэн хуульд хоёр удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эхний нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Ерөнхийлөгчийн эрх мэдлийг бага зэрэг хязгаарласан. Хоёр дахь нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн шалгуур дөчин таван нас хүрсэн байх гэснийг тавин нас хүрсэн байх, Ерөнхийлөгчөөр ажиллах хугацааг зургаан жил болгон өөрчилж, 31.7 дахь заалтын зөвхөн нэг удаа улируулан сонгож болохыг цуцалсан байна.
2. 1993-2013 оны Ерөнхийлөгчийн зургаан сонгуульд анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын саналаар Ерөнхийлөгч тодорчээ. Харин 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч сонгуульд оролцсон сонгогчдын олонхын саналыг аваагүй тул УИХ дахин санал хураалт зохион байгуулахаар шийдэж, 11 хоногийн дараа зохион байгуулсан. Мөн сонгогчдын оролцоо буурсаар байна. 2013 оноос хойш гадаадад амьдарч буй иргэд саналаа өгөх эрх нь нээгдсэн, “цагаан сонголт” нэмэгдсэн.
3. 1993 оноос хойш Ерөнхийлөгчийн сонгуулиудад үндэсний дэмжлэг авдаг, өргөн бүтэц, зохион байгуулалттай, улс төрийн туршлагатай МАН, АН-уудын нэр дэвшигчид сонгогдож иржээ.
4. 1993 оноос хойш долоон удаа зохион байгуулагдсан Ерөнхийлөгчийн сонгуулиудад нийт 20 нэр дэвшигч өрсөлдсөн. Үүнээс хамгийн их нэр дэвшигчтэй сонгууль нь 2005 онд дөрвөн нэр дэвшигчтэй, хамгийн цөөн нэр дэвшигчтэй сонгууль 1993, 2009 онд тус бүр хоёр хоёр нэр дэвшигчтэй байжээ.
5. Түүхэнд ганцхан эмэгтэй нэр дэвшигч өрсөлдөж байсан.
6. Сонгуульд зургаан зуун мянгаас дээш сонгогчийн дэмжлэг авсан хоёр, таван зуун мянгаас дээш санал авсан зургаан нэр дэвшигч байна. Бусад 12 нэр дэвшигч таван зуун мянгаас бага санал авчээ.
7. Ерөнхийлөгчөөр улиран сонгогдсон хоёр Ерөнхийлөгч байна. Бусад Ерөнхийлөгч нарын хоёр нь дахин нэр дэвшээд ялагдсан бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд нэг Ерөнхийлөгч нь дахин нэр дэвших эрхгүй болсон байна.
8. Ерөнхийлөгч нарын сонгогдсон насыг харахад дундаж нь 49.4-тэй байгаа нь залууд тооцогдоно.
9. Ерөнхийлөгчийн сонгууль нь УИХ-д суудалтай намуудын хувьд дараагийн шатны сонгууль бөгөөд намууд ч мөрийн хөтөлбөр дэвшүүлж идэвхтэй оролцдог. Учир нь УИХ дахь сөрөг хүчин Ерөнхийлөгчийн сонгуулийг төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх арга үздэг. Эрх баригч намууд эрх мэдлээ баталгаажуулах алхам гэж үздэг байна.



10. Өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулиудыг харахад ихэнх тохиолдолд Ерөнхийлөгч нь УИХ дахь сөрөг хүчнээс сонгогдож байна. Энэ нь хагас Ерөнхийлөгчийн засаглалтай улсад эрх мэдлийг улс төрийн намууд хувааж авах сонирхол, түүнд нийцүүлсэн кампанит ажлын технологитой холбоотой байх.
11. 1993, 1997, 2009, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд сөрөг хүчний нэр дэвшигчид ялалт байгуулж байжээ. Харин 2001, 2005 онд эрх баригч МАН-ын нэр дэвшигч, 2013 онд УИХ-д олон суудалтай АН-ын нэр дэвшигч Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж байжээ.
12. Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН-аас нэр дэвшихийн тулд нэлээд ширүүн өрсөлддөг. Энэ нь зарим тохиолдолд нам задрахад хүртэл нөлөөлж иржээ.
13. УИХ-д суудалтай гуравдагч хүчний намуудын хувьд болон шинээр байгуулагдсан улс төрийн намууд Ерөнхийлөгчөөр нэр дэвшүүлэх хүний нөөцгүй тул намын гаднаас нэр дэвшигчээ хайдаг.

Дүгнэж хэлэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ялахын тулд улс төрийн намууд хүчтэй өрсөлддөг нь намын төлөвшилд сөргөөр нөлөөлж байна.

## Ном зүй

1. *Монгол Улсын Үндсэн хууль*. (шинэчлэгдсэн эх) 1992 он  
<https://www.legalinfo.mn/law/details/367>
2. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулиуд*. 1993, 2012, 2020 [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)
3. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль*. (2012 он)  
[www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)
4. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүн*. 1993-2017 он. СЕХ. УБ., 2017 он.
5. *Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр*. 2021 оны 4 сарын 16-ны өдөр.  
Todd Landman Marco, Larizza Claire McEvoy (2005) *State of Democracy in Mongolia: A Desk Study*. International IDEA. [www.idea.int > files > pictures > sodMongolia05](http://www.idea.int/files/pictures/sodMongolia05)
7. Fritz, V. (2002) 'Mongolia: Dependent Democratization' *Journal of Communist Studies and Transition Politics*, 18 (4): 75-100.
8. Дефакто институт. *Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс*. 2018, 2019, 2020 он.
9. Г.Чулуунбаатар. (1999) *Монгол улсын төрийн байгууллагын шинэ тогтолцооны төлөвшилийн тулгамдсан зарим асуудал*. Шинэ толь №25
10. *Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал болон Орон нутгийн сонгуулийн хуулийн төсөлд өгөх АИХЭГ-ын санал*. ЕАБХАБ-ын АИХЭГ. Варшав хот, 2019 оны 11 сарын 25.
11. *ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль Ажиглах Хорооны Эцсийн тайлан*. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль* (2013 оны 6-р сарын 26 өдөр)
12. *ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлан*. *Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгууль*. (2017 оны 6-р сарын 26-н болон 7-р сарын 7-ны өдрүүд)
13. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн*. ҮСХ. [www.1212.mn](http://www.1212.mn)
14. *Сонгуулийн ирц (сонгогчдын бүртгэл)-ийн мэдээллийг ил тод болгох нь судалгаа*. (2021) АНУ-ын ОУХА, ОУБНХ, Азийн сан. Лийд төгсөгчдийн холбоо.  
[http://www.leadalumni.org/sites/default/files/Report\\_LEADAA.pdf](http://www.leadalumni.org/sites/default/files/Report_LEADAA.pdf)
15. Ерөнхийлөгчдийн авсан санал. ҮСХ. [www.1212.mn](http://www.1212.mn)
16. Транспаренси Интернейшнл Монгол. 2020 оны 1 сар.
17. Fernando Casel Bertao and Bat-Orgil Altankhuyag. *Are Presidential Elections Putting Mongolian Democracy in Peril?* <http://thediplomat.com/2021/05/are-presidential-election-putting-mongolian-democracy-in-peril/>